

## ОЙРАД МОНГОЛЧУУДЫН АН АГНУУРЫН ЗАРИМ ЗЭВСЭГ

### Б.БАТМӨНХ МУИС- Ховд дахь салбар

Ойрад Монголчуудын нутаглан сууж буй газар нутгийн байгаль газарзүйн байршлаас үүдэн сайхь нутагт ан амьтан элбэг. Алтайн уулсаар аргаль, янгир, ирвэс, шилүүс, үнэг, чоно, хярс, тарвага, булга, суусар, говь талд бөхөн, хар сүүлт, зээр, хулан зэрэг ан амьтад бий. Ойрадчууд эртний анчин гөрөөчин удамтай бөгөөд ан гөрөө нь тэдний ахуй амьдралд мал аж ахуйн дараа хоёрдугаар суурийг эзэлж байв. Ийм ч учраас Ойрад Монголчуудын ан агнуурт хэрэглэгдэж байсан уламжлалт арга, зан үйл, зэвсэг хэрэгслийг нэхэн судлах нь Монголын түүх угсаатан судлалын хойшлуулашгүй асуудлын нэг мөнөөс мөн.

Судлаачид Ойрадчуудын ан агнуурт хэрэглэж байсан уламжлалт агнуурын арга, зан үйлийн талаар зохиол бүтээлдээ ямар нэгэн хэмжээгээр хөндсөн хэдий ч харин зэвсэг хэрэгслийг хэрхэн хийж тавьж асан арга технологийн талаар шинжин судалсан нь нэн ховор. Галт зэвсэг түүний төрөл хэлбэр, тоо олшрохын хирээр уламжлалт зэвсэг хэрэгслээр ан агнах нь улам бүр хязгаарлагдаж буй өдгөө цагт түүнийг хийх, тавих арга технологи мартагдан бүдгэрсээр байна. Учир иймд бид Ховд, Увс, Баян-Өлгий аймгийн нутагт аж төрөн сууж буй Ойрад Монголчуудын дунд судалгаа хийж материал цуглуулан энэхүү өгүүллийг бичлээ.

Мөнхүү өгүүлэлд Баруун Монголын олон ястнууд дүүгүүр, басваг, суулга занга, дүүжиг урхи, сааль зэрэг зэвсэг хэрэгслүүдийг хэрхэн хийж тавьж байсан арга технологийн тухай өгүүлэх болно.

**Дүүгүүр.** Ойрад Монголчуудын ан агнуурт хэрэглэгдэж байсан хэрэгслийн нэг бол дүүгүүр бөгөөд нийт монголчууд нийтлэг хэрэглэж байв. Дүүгүүр нь маш эртний үүсэлтэй ба ардын аман уламжлалд:

Шөрмөсний хүчээр шагайн чинээ чулуу хонины хүчийг

Аргамжийн хүчээр аргалын чинээ чулуу адууны хүчийг олдог гэхчлэн өгүүлнэ.

**Дүүгүүрийн бүрдэл хийх арга.** Дүүгүүр нь таваг оосор хоёроос бүрдэнэ. Оосорыг 5-6 см өргөн, 15-18 см орчим урттай тавагны хоёр талаас нь 60-70 см орчим урттай гогцоотой, гогцоогүй хийнэ. Дүүгүүр нь таваг, оосортойгоо нийлээд 100-150 см орчим урттай. Тавгийг сүлжсэн сур, илгэ буюу булигараар хийдэг байжээ /зураг 1/. Таваг нь хэт өргөн бол дээр нь тавьсан чулуу шидэгдэхгүй, иймд гонзгой чулууг сонгодог нь хол тусахаас гадна нисэхдээ шүнгэнэсэн дуу гаргадаг байна.

**Дүүгүүрдэх.** Дүүгүүрийн тусгалын голч, байг онох нь дүүгүүрдэх хүний эв дүй, арга барилаас шалтгаална. Тусгалын голч нь ойролцоогоор 200-250 м хүрнэ. Дүүгүүрдэхдээ чулууг дүүгүүрийн тавагт тавиад гогцоотой оосорыг долоовор хуруугаар гогдож, нөгөө үзүүрийг нь тавихад чулуу шидэгдэж ан амьтныг цохиж агнана. Дүүгүүрийн чулуу маш ончтойгоос гадна хурд, хүч ихтэй байдаг. Сайн дүүгүүрддэг хүмүүс өдгөө ч дүүгүүрээр хааяа үнэг туулай зэргийг агнасаар байна.

**Басваг.** Ойрад Монголчуудын эрт үеэс хэрэглэсээр ирсэн багаж хэрэгслүүдийн нэг нь басваг юм. Басвагийг Ойрадын олон ястнууд өөр өөрөөр нэрлэнэ. Тухайлбал, торгууд, алтайн урианхайчууд "Baswag", захчинууд "Basmag" хэмээн нэрлэдэг байна<sup>1</sup>. Харин баядууд "хавчуурга" гэнэ.

**Басвагийн бүрдэл, хийх арга.** Басвагийг эрт дээр үеэс 1940-өөд он хүртэл түгээмэл хэрэглэж байв. Басваг нь шор, ивүүр, тулгуур зэргээс бүрдэл болно.

<sup>1</sup> Цолоо Ж. БНМАУ дахь Монгол хэлний нутгийн аялгууны толь бичиг. 2-р боть. УБ., 1986

Шорыг яргай хатуу хар /эмгэлж/, далан хальс зэрэг хатуу модоор 20-25 см урттай хийнэ.

Ивүүрийг 2-3 см орчим диаметртай, 5-7 см урттай бөөрөнхий модоор хийнэ.

Тулгуурыг 30-35 см орчим урттай, 1-2 см диаметртай хатуу модоор хийнэ.

**Басваг тавих.** Басвагийг тураг анд тавьдаггүй, харин булга, суусар зэрэг үслэг жижиг анд тавина. Басваг тавихын өмнө ангийн сан тавих, дуудлага дуудах зэрэг зан үйлүүдийг гүйцэтгэнэ. Анчин басваг тавихаар явахдаа тавих газрын ойролцоо очиж мэнгээ газар дээгүүр чирж тавих газраа ирнэ. Мэн гэдэг нь тарвага, адууны хальстай шөрмөслөг махаар бэлтгэсэн өгөөшийг хэлнэ. Мэнд тавих өгөөш нь заавал үнэртэй мах байдаг ажээ.

Чингээд мэнг басвагийн шоронд шорлоод, том жижиг хоёр чулууг сонгон авч жижгээр нь суурь болгон суурь дээрээ шортой мэнгээ тавьж, шорныхоо дээр тулгуураа тулж том чулууг түшүүр болгон тогтооно.

Ан амьтан дээр чирсэн мэнгийн үнэрийг дагаж эрсээр яваад басвагт тавьсан шортой мэнг идэх гэж оролдоход ивүүр нь өнхөрч, тулгуур нь тогтохоо больж уг амьтан хоёр чулууны завсар хавчуулагдан авлагдана. /зураг 2/

Басваг нь түрэг хэлний үг бололтой. Түрэгээр "басу" гэдэг нь дарах гэсэн үг ажээ<sup>2</sup>. Өөрөөр хэлбэл сайхь үг нь дарж агнана гэсэн утга илэрхийлнэ.

Басвагийг голдуу ан амьтны үс сор нь гүйцсэн өвлийн цагт тавина. Алтайн урианхайчууд тавьсан басвагаа цанаар явж эргэдэг ажээ. Энэ булга суусар зэрэг үслэг жижиг анг арьс үсийг гэмтээхгүй агнахад зориулагдсан ажээ.

Мөнхүү хэрэгслийг ан агнуурт Ойрад Монголчуудаас гадна Сибирийн Түрэгүүд нэлээд өргөн дэлгэр хэрэглэж байжээ. Тэд уг хэрэгслийг зөвхөн хэрмэнд тавьдаг байна. Мэдээлэгчдийн өгүүлж байгаагаар гүйдэл тосгуулан 200-500 болон 1000 хүртэл басваг тавьдаг ажээ.

Басваг нь хийц болон бүтцийн хувьд маш эгэл. Энэ нь цул банз, хагас гуалин хоёроос бүрддэг бөгөөд урт нь ойролцоогоор метр, өргөн нь 30-70 см байдаг байна. Хэрэм агнахын өмнө өгөөшинд тосорхог мөөг, сүүнд зуурч болгосон гурил зэргийг хэрэглэдэг байна<sup>3</sup>.

Басвагийг Алтайн урианхайчууд Манжийн эзэн хаанд үслэг эдлэлийн алба барих болсон үеэс хэрэглэж эхэлсэн хэмээн домоглодог. Хэрэг дээрээ басвагийн эгэл хийц, ажиллагааны маш энгийн зарчимаас үүдээд нүүдэлчдийн дунд маш эрт үед үүссэн болох нь илт байна.

**Суулга занга.** Суулга зангыг Алтайн урианхай, баяд, дөрвөдүүд булга, суусар зэрэг үслэг жижиг ан агнахад хэрэглэдэг байжээ. Суулга зангыг модоор жижиг бортого хийж, хавхагийг /таглаа/ дотогшоо эргэж хаагддаг байдлаар хийнэ.

Суулга зангыг тавихдаа тарвага, зурам, бозлого, адуу зэрэг амьтдын үнэртэй махыг суулганы аманд эргэлдэх хөдөлгөөнтэй хавхаган дээр тавьж хаданд өлгөж орхино. Уг зангыг заавал хаданд өлгөдөг, эс өлгөвөөс занганд орсон ан савтайгаа хамт өнхөрч, таг нээгдэж болох учраас газар тавьдаггүй.

Суулганы аманд эргэлдэх хөдөлгөөнт хавхаган дээр буй жижиг махыг ан амьтан идэх гээд үсэрч очмогц хавхаг нь дотогшоо эргэж, сав уруу унамагц хавхаг хаагдаж онгойхгүйгээр таглагддаг байна. Эл зангыг ан амьтны үс сор гүйцсэн өвлийн дунд сараас хаврын дунд сар хүртэл хугацаанд тавьдаг байжээ.

**Дүүжин урхи.** Дүүжин урхийг Ховд, Увс аймгийн нутагт аж төрөн сууж буй торгууд, баяд, дөрвөд ястнуудын ан авд хэрэглэх нь түгээмэл тархжээ. Энэ урхийг ихэвчлэн мод бургастай газар тавина. Дүүжин урхиар үнэг, хирс, мануул, туулай

<sup>2</sup> Б.Базилхаан. Казак Монгол толь. УБ., 1977

<sup>3</sup> Турки таежного Причудья. Томск., 1991

зэрэг амьтдыг агнана. Урхи тавихдаа гурван модыг үзүүрээр нь зөрүүлэн боогоод түүний салаан дээгүүр нь унанги модыг дамнуулан тавьж нарийн үзүүрт нь урхиа уяж унжуулаад мах өөхний зүйлийг газарт хаяна. Дамнуулж тавьсан модны үзүүрийг ойролцоо буй ургаа модны яр, уранд мөчидхөн тээглүүлнэ. Чингээд амьтан ирж урхины өгөөшийг идэж байгаад урхинд орж хөдөлгөхөд дамнуурга мод хөдөлж тээглүүлсэн бүдүүн модны үзүүр нь мултран унахад урхинд орсон амьтан дээш татагдан дүүжлэгдэн авлагдана /зураг 4/. Урхийг адууны дэл, сүүл, сарлагийн савгаар нарийхан томж бэлтгэдэг байна.

Дүүжин урхийг дээрх аргаар тавихаас гадна ургаа модыг татаж бөгтөрлөөд тавьдаг бас нэг арга бий. Энэ аргаар урхийг тавихдаа газарт тээглүүр бүхий гадас шааж хөндлөвчөөс дээш урхиныхаа уяаг гарган ургаа модны нойтон мөчрийг татаж махийлгаад урхиа оньсолно. /зураг 5/

Оньсолсон урхины дор өгөөш хаяна. Ямар амьтан агнах гэж байгаагаас шалтгаалаад өгөөшөө тавина. Тухайлбал, үнэг, хирс агнах гэж байгаа бол мах өөхний зүйл, туулай агнах гэж буй бол өвс тавина. Улмаар ан ирж өгөөшийг идэж байгаад урхинд орж хөдөлгөхөд оньс мултарч нумлан татсан мөчир чавхдан хэвэндээ орж уг амьтан дүүжлэгдэнэ<sup>4</sup>.

**Сааль.** Монголчуудын ан агнуурт хэрэглэж байсан зэвсэг хэрэгслийн нэг бол сааль юм. Саалийг монголын олон ястнуудын дотроос Алтайн урианхай, Тува, Цаатангууд түгээмэл хэрэглэж байлаа. Сааль нь нум, хөвч, сум, зэв, суурь, оньс, хэц зэргээс бүрдэл болно. /зураг 6/

**Саалийн нум.** Бургас модыг дурсалж шүүслэн хатаагаад саалийн нум хийх хэмжээгээр огтолж халуун нурманд дүрж бага зэрэг малталт хийж засна. Ийнхүү засалт хийсний дараа хоёр үзүүрээс нь 3-4 см орчим зайд хөвч уях хэрчлээс гаргана.

**Хөвчийг** ямааны татаасыг нойтон байхад нь 2 давхарлан эрчилж гадсанд татан хатааж хийхээс гадна үхрийн шөрмөсөөр хийдэг.

**Сум.** Бургас, сухай зэрэг хөнгөн бөх модоор залж тэгшлэн хийнэ. Сумны мөсний төгсгөлийн хэсэгт ац гарган хонины нарийн гэдэс болон хоолоор /улаан хоолойн хальс/ бүрэх буюу цавуутай шөрмөсөөр ороож өгнө. Ац /онь/ нь хөвчний диаметртэй адил хэмжээтэй байна. Сумны төгсгөлийн хэсэгт оньсны тээглүүр гаргана.

**Зэв.** Төмрөөр гурван талтай, хавтгай гэх мэт олон янзаар хийдэг ажээ.

**Суурь.** 120-130 см урттай хавтгай мод сонгон авч үзүүрийн хэсэгт нь 35-45мм орчим урттай хоорондоо 3-5 см зайтай чиглүүлэгчийг суурьтай нь сур, үдээрээр холбож өгнө. Саалийн сууринд саалийн нум бэхлэх хоног гаргаж өгнө. Саалийн нөгөө үзүүрт нь 7-10 см орчим зайд пирамид хэлбэртэй оньсны нүх гаргана. Суурийн хоёр талд нь тус бүр гурав, урд, хойд талд нь тус бүр нэг оосор байх бөгөөд оосроор газарт гадаслан бэхэлдэг байна.

**Оньс.** Суурь модны зузаанаас хамаарч янз бүрийн урттай хийнэ. Оньсыг яргай, буйлс, эмгэлж зэрэг хатуу модоор хийнэ. Оньсны гадаргууг маш сайн өнгөлнө. Оньсны бүдүүн талд нь 2-3 мм орчим диаметртэй хэц бэхлэх нүх гаргана.

**Хэц /зэл/. Хэцийг** адууны сүүлний 3-6 ширхэг хялгасаар 200-225 метр орчим урттай томж бэлтгэнэ. Хэц нь сааль тавих газрын өнгөтэй ойролцоо өнгөтэй байна. Иймд анчин 2-3 янзын хэцтэй явдаг ажээ.

**Сааль тавих.** Сааль тавихаас 2-3 хоногийн өмнө үнэр цохихоос сэргийлж тавих газраа авчирч орхино. Саалийг ангийн гүйдэлтэй онь хөтөл бүхий газар тавина. Гүйдэл бүхий орчинд гүйдэл тосгуулан хэд хэдэн саалийг тавьж болно. Сааль тавихаасаа өмнө сан тавих, дуудлага дуудах зэрэг зан үйлүүдийг гүйцэтгэнэ. Сааль тавихдаа эхлээд хэцний үзүүрийг эсрэг талд нь бэхэлж саалиа суурилуулан нумаа

<sup>4</sup> Б.Батмөнх. Ойрад Монголчуудын ан агнуурын уламжлалт зэвсэг. Ховд 1997

татаж уяагаа тохируулж бэхэлдэг. Саалийг тухайн ангийн өндөр намыг харгалзан суганд нь харвахаар тохируулж тавина.

Тавьсан газар, сааль эргэх талаа тус бүр шав тавьж тэмдэглэдэг байна. Сааль тавьсан газар, байлгах хугацаагаа нийтэд зарлана. Мөн саалиа тавих, хугацаанаас өмнө буулгавал буулгасан тухайгаа нийтэд мэдэгдэнэ.

Сааль нь маш осолтой зэвсэг байсан тухай настайчуул олонтоо дурсан өгүүлдэг билээ. Тухайлваас, сааль тавьсан зар сонсоогүй хүн саалинд өртөх төдийгүй сааль тавигч өөрөө ч өртөж байжээ. Үүнийг нотлох баримт бол Алтайн Урианхайчуудын дунд яригддаг:

Саальч хүн саалиндаа

Хадач /уулч/ хүн хадандаа

Усч хүн усандаа үхдэг гэдэг үг хэллэг болно.

Тэгээд ч саалийг дуртай хэн нэгэн тавьдаггүй, харин түүнийг тавьдаг мэргэшсэн анч цөөхөн байсан ажээ.

Монголын дунд үеийн хуулийн дурсамжуудад саалийг тавих бүрдээ заавал зарлаж байхыг хуульчлан тусгаж байжээ. 1640 оны “Дөчин дөрвөн хоёрын их цааз”-ын бичигт саальтай холбоотой хэд хэдэн заалт бий. Үүнийг дор сийрүүлвээс:

Jartu saalidu kumun ukukule nige berkeer bosqo, edegekule γdi ugei

Jartai galayai saalidu kumun ukukule γurban yesutu, joboji edegekule moritai solo oq

Jar-ugei saalidu kumun ukukule tabun yesutu bui, edegekule tabutu

Jar-ugei /saalidu/ yamar bese mal ukukule maliyin kireer bosqo, jartai bolxula γai ugei

Saalidu ukuqsen guroesuni ejeni idetugei<sup>5</sup> гэжээ. Эдгээр заалтуудад саалийг зартай тавих, саальд орсон анг анчин өөрөө хүртэж байхыг хуульчлан тусгасан байна.

XVII зууны үеийн Монголын хууль эрхэмжийн чухал дурсгал болох “Халх журам” хуульд сааль зэвсгийн талаарх заалт мөн бий. Үүнийг дор сийрүүлбээс: “... Томгын саалинд шилүүрдэж хүн үхвээс хүн, тэмээний нэгээр ор босгоод зуун анз өгөх. Ер нь шөл өгч өвчлөлцтүгэй. Эдгэвээс ямуту хүнд тайлаг тэмээ, яму - үгүй хүнд хязаалан морь бөглөө өгөх буй. Ер нь суурин хүний бэлчээр дээр саальч хүн шогоор зүүгээд түүнд ямар мал өгвөөс түүнийг төлөх. Хэдүй мал харуулваас өвчлөх, ачих, унах, саах малын оронд эдгэтэл унах, ачих, үхэх, шоглож зүүсний алданги шүдлэн морь өгөх. Томгын сааль их зам дээр бус зүү. Хулгай саалинд хүн гэмтэж үхвээс ташаарсан лугаа мал үхвээс орыг холбоодыг төлөх буй. Бас саалиа гадагш таван зуун алд газар ч нааш үхсэн гөрөөсийг авахуулаад нэг шүдлэн морьт ер алсан гөрөөснөөс мэрэг, гур хоёрыг авах”<sup>6</sup> гэжээ.

Саалийг зартай тавихаас өөр аргагүй осолтой зэвсэг байсан тухай нэгэн аман мэдээг сонордуулъя. Хэл шинжээч Г.Жамъяны бүтээлд “1750 –иад оны орчимд Манжийн хаан дөрвөдүүдийг одоогийн Улаангомын газар суулгахад Увсын хойт хэсгээр нутаглан сууж байсан тувачууд нутаг шахагдан аргагүйн эрхэнд нүүхдээ саалиа буулгалгүй явснаас болж олон хүн өртөж шархдан, шархаа эдгээхийн тулд хүн орхоодой гэдэг ургамлаа дуусгасан юм гэж манай нутгийн өвгөчүүл ярьдаг байсан” гэжээ.

Баруун Монголын олон ястны дунд “саалийг сарын газар тавина” гэлцдэг. Энэ нь хүн, мал явахгүй алс газар гэсэн үг юм. Ховд аймгийн Чандмань сумын нутаг Занын булгаас Хаа гүний доод усны доогуур гарч урагш чиглэн Мөнгөн овооны үзүүр хүртэл зэл чулуу эгнүүлэн татсаныг нутгийн хүмүүс “Саалийн хил” хэмээн ярилцдаг билээ. Үнэхээр ч сааль байнга тавьдаг газарт хөл хорих үүднээс хил тавьдаг байсан ч байж

<sup>5</sup> С.Д.Дылыкова. Великое уложение. М., 1981. стр 50

<sup>6</sup> Халх журам. УБ., 1963. /хэвлэлд бэлтгэсэн Х.Пэрлээ/

магадгүй. Мөн Баян-Өлгий аймгийн Алтанцөгц сумын нутагт “Долоон саалийн үүдэн” хэмээх нэртэй нутгийн хүмүүс сааль тавьж байсан тусгай газар ч байсан байна.

Саалийг Монголчуудаас гадна Тожийн Тува нар ан агнуурт түгээмэл хэрэглэж байжээ. Тувачуудын хэрэглэж явсан сааль зэвсгийн тухай Оросын эрдэмтэн С.И.Вайнштейн “... Ан агнуурт өргөн хэрэглэгдэж байсан цорын ганц хөнөөгч зэвсэг нь сааль юм. Саалиар хандгай, марал буга, зээр, үнэг, чоно, баавгай, минж, хэрэм зэрэг амьтдыг агнадаг байв. Олонхи анчид, ихэвчлэн өвгөчүүл /тэдний хувьд сааль нь үндсэн зэвсэг болсон нь тайгад ан амьтныг мөрдөн мөшгөхөд хүчин мөхөсддөг байв/ олон арван саальтай байжээ ... XIX зууны эхээр саалиар ан хийхийг хориглож улмаар хэрэгцээнээс гарч эхэлсэн хэдий ч 1931 онд Тожуудад 1210 сааль бүртгэгджээ.

Саалийн суурийг шинэс /навчит/ модоор хийнэ. Суурийн урд /өмнө/ хэсэгт нум бэхлэгдэнэ. Суурийн дээд хэсэгт сумны ховил гаргана. Нуманд үдээрээр хийсэн хөвчийг хялгасан гогцооны тусламжтайгаар модон гохонд тогтооно. Гогцоонд хялгасаар томсон урт хэц бэхэлж ан амьтны замыг хаах бөгөөд хэцэнд ан амьтан хүрсэн тохиолдолд гох мултарч харвана. Саалийн өндрийн хэмжээг тохируулдаг. Иймээс анчид ангийн өндөрт тохирсон тусгай хэмжигчтэй байжээ. Булга, минж агнахад хажуу талдаа сэртэнтэй /өргөстэй/ зэв хэрэглэдэг бөгөөд зэвнээс урт хялгасан оосор уяна. Нохой зээх агнахдаа үзүүртээ тээглүүр бүхий ацтай зэв хэрэглэнэ. Туулай, хэрэм зэргийг агнахдаа мод, яс, төмрөөр хийсэн хавтгай зэвүүдийг хэрэглэнэ. Сумыг өдгүй хийдэг”<sup>7</sup> хэмээн тэмдэглэжээ.

Сааль зэвний тухай Монгол ардын оньсогууд бий. Үүнд:

1. Шугуй дотор  
Сохор чөтгөр
2. Хаданд хатсан чөтгөр  
Хамаг юмыг гэтсэн чөтгөр
3. Хээр гэтсэн чөтгөр  
Хэрэг тарьсан чөтгөр
4. Харгуйд хатсан чөтгөр  
Харанхуй шөнө отсон чөтгөр
5. Хажууд хар чөтгөр /сааль/<sup>8</sup> гэжээ.

Эдгээр оньсогууд нь хадтай, модтой газарт тавьдаг саалиуд байсныг гэрчилж байна. Бидний энд өгүүлэн буй Алтайн Урианхайчуудын ан агнуурт хэрэглэж байсан сааль бол хадтай газар тавьдаг сааль бөгөөд харин С.И.Вайнштейны бичсэн Тожийн Тувачуудын сааль нь модтой газар /ой хөвчид/ тавьдаг сааль болно. Эдгээр саалиуд нь тэдний аж төрөн сууж буй газар нутгийн байгаль газарзүйн байршлаас үүдэн хийх, тавих арга барилын хувьд бага зэргийн ялгаа буй хэдий ч харвах зарчмын хувьд адил байна.

Сааль зэвсгийг Монголчууд болон Тожийн Тува нараас гадна Сибирийн тайгын Түрэгүүд ан агнуурт өргөн дэлгэр хэрэглэж байжээ. Тэд саалийг Ок хэмээн нэрлэнэ<sup>9</sup>.

Жич дурьдахад, сааль зэвсгийг зөвхөн ан агнуурт төдийгүй дайн самуун, хөл үймээн ихтэй үед мөн тавьж байжээ. Магадгүй дээр өгүүлсэнчлэн Тува нар нутаг шахагдан гарахдаа хорсон зэвүүцэхийн эрхээр зориуд саалиа буулгалгүй явсан ч байж болох юм. Ямар боловч энэ мэдээгээр саалийг зөвхөн ангийн төдийгүй үймээн

<sup>7</sup> С.И.Вайнштейн. Тувинцы Тоджинцы. Историкоэтнографические очерки. М., 1961

<sup>8</sup> Монгол ардын оньсого таавар. Уб., 1990

<sup>9</sup> Турки таежного Причулымья. Томск., 1991


самуунтай үед эсрэг этгээдээ хөнөөх зэвсэг болгон хэрэглэж байсны тодорхой баримт болж байна.

Эцэст нь тэмдэглэхэд ойрад монголчуудын өөрсдийн нутаглаж буй орон нутгийнхаа байгаль газарзүйн байдлаас үүдэн ан агнуурын зэвсэг, хэрэгсэл хийх тавих өвөрмөц арга барилтай болжээ.


Ан араатны зан төрх, идэш хоолоо эрж гүйх өдөр шөнийн гүйдлийг маш нарийн ажиглан практик мэдлэгийг хуримтлуулж энэ үндсэн дээр ан агнуурын зэвсэг хэрэгслүүдийг үйлддэг байна.

Дээрх зэвсэг хэрэгслүүд нь ан амьтныг эх нутгаас нь хулжаахгүй, байгаль экологийн тэнцвэрт байдлыг хангахад чухал ач холбогдолтой байсан байна.


# ХАВСРАЛТ




Зураг №1 Дүүгүүр




Зураг №2 Басваг




Зураг №3 Суулга занга



Зураг №4 Дүүжин урхи



Зураг №5 Дүүжин урхи



Зураг №6 Дүүжин урхи